



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 19 өдөр

Дугаар A/28.

Мөрөн сум

“ЕБ-Сургуулийн дотуур байрны тохижилт, спорт
заалны засвар”-ын ажлын явцад хяналт тавих, хүлээн
авах комиссыг байгуулсугай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2025 оны 03 сарын 27-ны өдрийн А/51 тоот захирамжаар байгуулагдсан Сумын үнэлгээний хорооны 2025 оны 04 сарын 21-ний өдрийн 02 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. “Кэй Эл Си Си”- ХХК нь сумын ОНХ сангийн хөрөнгө оруулалтаар ЕБ-Сургуулийн дотуур байрны тохижилт, спорт заалны засварын” ажлын тендерт ялж 2025 оны 06 сарын 15 -с 2025 оны 08 сарын 15 -ны дотор хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан тул уг ажлын явцад хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хүлээн авах эрх бүхий сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Комиссын дарга:	М.Ариунаа	Сургуулийн захирал
Гишүүдэд:	А.Алимаа	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Э.Балчиндорж	Цагаан толгой багийн засаг дарга
	Г. Загдцэсэм	Сургуулийн жижүүр
	Б.Нөхөрлөл	Сургуулийн нярав

2. “Кэй Эл Си Си” ХХК -аас хүлээн авах “ЕБ-Сургуулийн дотуур байрны тохижилт, спорт заалны засвар”-ын ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн өнгө үзэмж, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг комиссын дарга (М.Ариунаа)-д үүрэг болгосугай.

3. Засварын үйл ажиллагаанд захиалагчийн зүгээс хөндлөнгийн хяналт хийхдээ Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан Захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлж, үйл ажиллагааныхаа чиглэлээр Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай нягт хамтарч ажиллахыг комиссын нийт гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Н.НАМЖИЛНОРОВ

